



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 47221

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл шинээр олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3, 15.8, 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 8.1.12.13, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2023 оны А/419 дүгээр тушаал, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/219 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох (1) хуулийн этгээдийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Захирамжийг холбогдох байгууллагуудад хүргүүлж, хууль, дүрэм журам, стандартыг зөрчсөн нь тогтоогдвол тусгай зөвшөөрлийг цуцалж хуулийн этгээдэд мэдэгдэхийг Ажлын хэсэг (Г.Дагвадорж)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар), Цагдаагийн хэлтэс (Т.Лхагвасүрэн)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

А.СҮХБОЛД





Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг дархын
2024 оны 04 дугаар сарын 24. ны өдрийн
дугаар захирамжийн хавсралт

СПИРТИЙН ӨНДЭР БОЛОН СУЛ АГУУЛАМЖТАЙ СОГТУУРУУЛАХ УНДААГААР ҮЙЛЧЛЭХ ТУСГАЙ ЗӨВШГӨӨРӨЛ
ШИНЭЭР ОЛГОХ ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН НЭРИЙН ЖАГСААЛТ

№	Д/д	Хуулийн этгээдийн РД	Хуулийн этгээдийн РД	Албан тушаал, нэр	Оноосон нэр	Ангилал	Төрөл	Хороо	Хаяг байршил
1	2	3	4	5	6	7	8	9	10
03	1	"Их хараат сонор" ХХК	7048409	Захирал Д.Цэвэгдорж	Like	Баар/караоке	14:00-04:00	2	Замчин (12314) гудамж 102 тоот